

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ


Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын хүүхдийн хоёр дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2026/153/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com
2026 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Уужим Алтай Аудит ХХК-ны Захирал: Г.Ганболд
	Утас: 99117121 Цахим хаяг: Uujimaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫ ДҮГНЭЛТ

 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgii@audit.gov.mn	НОГООННУУР СУМЫН ХҮҮХДИЙН 2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Т.ГҮЛМАЗАТ ТАНАА
<u>2026.02.25</u> № <u>225</u> танай _____-ны № _____-т	
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Асуудлыг онцолсон хэсэг	
<p>Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь 2025 онд 1,618.6 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,590.5 сая төгрөг зарцуулж, 98.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.</p>	
Аудитын гол асуудал	
<p>Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.</p>	
Бусад асуудлын хэсэг	
<p>Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.</p>	
832605000300	

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГУЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,618,618,400.00	1,590,567,967.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,618,618,400.00	1,590,567,967.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,618,618,400.00	1,590,567,967.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,312,819,700.00	1,288,503,981.34
210101	Үндсэн цалин	833257300.00	790325590.30
210102	Нэмэгдэл	442022000.00	417627615.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	40024251.54
210104	Урамшуулал	37540400.00	40526523.70
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	163,424,900.00	163,424,900.00
210201	Тэтгэврийн даатгал	110912100.00	110912100.00
210202	Тэтгэмжийн даатгал	13128200.00	13128200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6564100.00	6564100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6564100.00	6564100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26256400.00	26256400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,459,700.00	22,459,022.00
210301	Гэрэл, цахилгаан	7494000.00	7493322.00
210302	Түлш, халаалт	14965700.00	14965700.00
2105	Нормативт зардал	83,466,600.00	82,175,350.00
210502	Хоол, хүнс	83,466,600.00	82,175,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	266,900.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	266,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,695,200.00	4,014,264.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,695,200.00	4,014,264.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,752,300.00	29,723,550.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,718,700.00	21,697,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,033,600.00	8,025,650.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,618,618,400.00	1,521,558,222.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,499,453,100.00	1,498,832,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,499,453,100.00	1,498,832,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,459,700.00	22,725,922.00
132001	Орон нутгийн төсвөөс	23,459,700.00	22,725,922.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	95,705,600.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	95,705,600.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		102,501,621.95
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		33,491,876.61
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40.00	40.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00
620003	Үйлчлэх ажилтан	17.00	17.00

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой 243.1 сая төгрөгийн алдаа илэрч, аудитын явцад 243.1 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан. *Залруулсан алдаа:*

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвөөс санхүүжих 138.7 сая төгрөгийг төлөвлөгөөнд дутуу тусгаж, зардлын төлөвлөгөөг 96.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Үр дүнгийн тайланд 8.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдсанаас үүссэн гарзыг тусгаагүй, буруу тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар зөрчил илрээгүй.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Аудитаар 13.3 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгөв.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалт, хяналттай холбоотой асуудал

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлын төсвөөс нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоонд 10.1 сая төгрөгийг илүү шилжүүлсний улмаас авлага үүссэн бөгөөд ХАОАТ-ын 3.2 сая төгрөгийн өр бий болсон байна. Энэ нь төсвийн зарцуулалтад зохих журмын дагуу хяналт тавьж ажиллаагүйтэй холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын шимтгэлд илүү шилжүүлж авлагыг 2026 оны тооцоонд оруулж бүрэн барагдуулах, үндэслэлгүй авлага үүсгэхгүй байх. анхан шатны баримт бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байхыг зөвлөмж болгов.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Ногооннуур сумын хүүхдийн хоёр дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруула агүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТГТ-г зөрүүтэй тайлагнасан	1	235,194.2	1	235,194.2			1	235,194.2				
ҮДТ-д үндсэн хөрөнгө худалдсанаас үүссэн гарзыг тусгаагүй, буруу тайлагнасан байна.	1	8,403.7			1	8,403.7	1	8,403.7				
Дүн	2	243,597.9	1	235,194.2	1	8,403.7	2	243,597.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
НДШ-д 10.1 сая төгрөгийг илүү шилжүүлж авлага,, ХХОАТ-т 3.2 сая төгрөгийн өглөг үүсгэсэн	1	13,356.5					1	13,356.5				
Дүн	1	13,356.5					1	13,356.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Ногооннуур сумын хүүхдийн хоёр дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								